



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2008 оны 09 сарын 06 өдөр

Дугаар 93

Номгон

Эрдэнэцогт, Баянхонгор сумын хилийн цэсэд
өөрчлөлт оруулах, тодотгох талаар санал, дүгнэлт
гаргах ажлын хэсэг байгуулах тухай

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1977 оны 75 дугаар зарлигаар батлагдсан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хилийн цэсээр Эрдэнэцогт сумын нутагт байгаа “Шаргалжуут” орчмын газрын хилийн цэсэд өөрчлөлт оруулах саналыг аймгийн Засаг даргаас ирүүлсэн. Мөн саналд Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Элбэнхийн 5 дугаар багийг татан буулгаж, Баянхонгор сумын 8 дугаар баг үүсгэсэн ч хилийн цэсийн асуудал нь Монгол Улсын Их Хурлаар эцэслэн шийдвэрлэгдээгүй байгааг ТЭМДЭГЛЭЭД:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 28 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Газар зохион байгуулалт хийх журам”-ын 6.1, 17.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрдэнэцогт, Баянхонгор сумын хилийн цэсэд өөрчлөлт оруулах, тодотгох талаар санал, дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийг ахлагч Д.Мөнхсайхан (Аймгийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга Д.Алтангэрэл (Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга)

Гишүүд Ц.Төмөрбаатар (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч)

Ж.Дашцэрэн (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч)

Т.Норов (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

М.Насанбат (Баянхонгор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга)

Б.Энхбаатар (Эрдэнэцогт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга)

Ж.Мөнхсоёл (Баянхонгор сумын Засаг дарга)

Д.Цэвэгдорж (Эрдэнэцогт сумын Засаг дарга)

0121195

Б.Отгончимэг (Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн)

Холбогдох сумдын багийн Засаг дарга, газрын даамлууд

Иргэний төлөөлөл

2. Хилийн цэсэд өөрчлөлт оруулах талаар холбогдох хууль, журам зааврын дагуу сумдын багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлэн санал авах ажлыг зохион байгуулж 2021 оны 12 дугаар сарын 25-ны дотор ажлын хэсгийн дүгнэлтийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Норов)-д даалгасугай.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан 2019 оны 97 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

